



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 493

Улаанбаатар хот

Хөрөнгө акталж данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2, 6.3.4, 6.4.3, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 57 нэрийн, нийт 267,377,796.13 (хоёр зуун жаран долоон сая гурван зуун далан долоон мянга долоон зуун ерэн зургаан төгрөг арван гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 251,780,395.93 (хоёр зуун тавин нэгэн сая долоон зуун наян мянга гурван зуун ерэн таван төгрөг ерэн гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Харилцаа холбооны зохицуулах хорооны Г.Чинзоригт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Акталж данснаас хасах хөрөнгөөс сэлбэг, хоёрдогч түүхий эд, мод, төмрийн хаягдлыг ялган тоолж бүртгэх, худалдах, орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Барилга, байгууламжийн доорх газрын эзэмших эрхийг төрийн байгууллагын мэдэлд хэвээр үлдээж, зориулалтын дагуу ашиглах, барилгыг буулгаж газрыг нөхөн сэргээх ажил зохион байгуулах;

2.4. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.5. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132002261

22-r huraldaan.docx